БИЗКОН АУДИТ ХХК-ИЙН ХӨВСГӨЛ САЛБАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ХӨА-2022/137/НА-СТА-ТШ3**


| | |
|---|---|
| Цахим хуудас:<br>www.audit.mn<br>Мөрөн сум<br>2022 он | Аудитын газрын дарга,<br>тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар<br>Утас: 70383793 Цахим хаяг: erdenebaatar@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ<br>Утас: 99900662 Цахим хаяг:bat-erdenee@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор:<br>Утас: Л.Отгонбаяр Цахим хаяг: imfo@bizkon.mn<br><br>Аудитор:Ч.Мөнхбаяр<br>Утас: 99996784 Цахим хаяг: mm.bayar0711@gmail.com |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**


1.Аудитын санал дүгнэлт....3

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл....4

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан....4

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан....5

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан....7

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....7

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан....9

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан....11

3. Аудитын тайлан....13

3.1 Ерөнхий зүйл....13

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт....13

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал....14

3.4 Материаллаг байдал....14

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга....14

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв....15

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг....15

3.8 Аудитын гол асуудал....16

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал....16

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт....16

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....16

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал....16

4. Аудитын илрүүлэлт....17

4.1 Залруулсан алдаа....17

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл....17

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ХӨА | Хөвсгөл аймаг |
| НА | Нотлох аудит |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| ҮОМШӨ | Үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин |
| НБББББ | Нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн Хурал |

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2022.02.21 № 01/97
танай ____________ -ны № ____________ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦАГААН-УУЛ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА Н.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **67,959,268.59** | **287,719,484.33** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 00.00 | 464,878.17 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 00.00 | 464,878.17 |
| **3121** | **Төгрөг** | 00.00 | 464,878.17 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 00.00 | 74,474.17 |
| 31215 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | 00.00 | 390,404.00 |
| **33** | **АВЛАГА** | 00.00 | 52,805,200.00 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 00.00 | 52,805,200.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 67,959,268.59 | 234,449,406.16 |
| **351** | **Түүхий эд материал** | 40,625,560.78 | 169,850,465.05 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 19,959,876.13 | 00.00 |
| 35130 | Эм боох материал | 20,665,684.65 | 169,850,465.05 |
| **354** | **Хангамжийн материал** | 27,333,707.81 | 64,598,941.11 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 5,061,460.00 | 8,587,480.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 15,907,033.00 | 45,791,273.61 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 1,350,000.00 | 1,350,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,318,550.28 | 2,371,980.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 1,831,770.00 | 863,970.00 |
| 35460 | Хүнсний материал | 1,864,894.53 | 5,634,237.50 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **434,001,646.44** | **618,088,891.70** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 434,001,646.44 | 618,088,891.70 |
| **392** | **Биет хөрөнгө** | 405,468,146.52 | 604,184,141.82 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 330,915,290.00 | 330,915,290.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -54,350,966.24 | -79,998,854.36 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 88,626,896.00 | 68,686,896.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -39,185,114.40 | -32,492,652.54 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 111,733,361.90 | 248,858,125.22 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -71,919,610.38 | -41,775,776.22 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 45,892,391.80 | 121,825,091.80 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -7,294,960.72 | -12,558,825.96 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 1,829,200.00 | 1,829,200.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -778,341.44 | -1,104,352.12 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 28,533,499.92 | 13,904,749.88 |
| 39301 | Программ хангамж | 16,000,000.00 | 715,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -862,500.08 | -206,250.12 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 13,396,000.00 | 13,396,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **501,960,915.03** | **905,808,376.03** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **501,960,915.03** | **905,808,376.03** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 501,960,915.03 | 905,808,376.03 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 226,654,626.00 | 226,654,626.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 226,654,626.00 | 226,654,626.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 39,158,907.88 | 443,754,718.88 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 39,158,907.88 | 39,907,257.88 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 403,847,461.00 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 236,147,381.15 | 235,399,031.15 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **501,960,915.03** | **905,808,376.03** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **Үйл ажиллагааны орлогын дүн** | **771,107,606.71** | **1,570,861,112.73** |
| **11** | **Татварын орлого** | **00.00** | **00.00** |
| **12** | **Татварын бус орлого** | **96,922,396.71** | **526,790,102.73** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 96,922,396.71 | 526,790,102.73 |
| **13** | **Тусламж, санхүүжилтийн орлого** | **674,185,210.00** | **318,994,310.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 617,979,900.00 | 00.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 617,979,900.00 | 00.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 00.00 | 725,076,700.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 13,131,800.00 | 231,293,520.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 9,972,600.00 | 984,075.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 59,627,746.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 3,159,200.00 | 1,326,699.00 |
| 131107 | Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого | | 169,355,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 00.00 | 72,219,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 00.00 | 72,219,900.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 43,073,510.00 | 15,480,890.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 43,073,510.00 | 15,480,890.00 |
| **2** | **Үйл ажиллагааны зардлын дүн** | **713,027,936.07** | **1,136,751,151.73** |
| **21** | **Урсгал зардал** | **713,027,936.07** | **1,136,751,151.73** |
| **210** | **Бараа, ажил үйлчилгээний зардал** | 709,593,898.29 | 1,092,351,151.73 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 441,667,089.23 | 492,771,113.00 |
| 210101 | Үндсэн цалин | 273,879,789.23 | 309,621,359.00 |
| 210102 | Нэмэгдэл | 122,254,400.00 | 110,000,000.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 7,392,000.00 | 6,986,000.00 |
| 210104 | Урамшуулал | 38,140,900.00 | 50,528,754.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 00.00 | 15,635,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 55,283,072.59 | 64,447,828.83 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 38,052,555.96 | 45,060,888.83 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,307,655.63 | 4,922,368.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,445,983.00 | 3,937,973.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 861,269.00 | 979,875.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,615,609.00 | 9,546,724.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 49,166,900.00 | 68,219,900.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,730,809.00 | 5,122,150.00 |
| 210302 | Түлш, халаалт | 44,066,091.00 | 61,089,600.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 370,000.00 | 2,008,150.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **23,458,009.76** | **64,569,745.08** |
| 210401 | Бичиг хэрэг | 4,937,608.00 | 3,482,066.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 11,778,735.50 | 19,286,695.28 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 200,066.00 | 2,918,059.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,115,559.90 | 3,737,849.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,099,900.00 | 29,077,177.02 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 3,326,140.36 | 6,067,898.78 |
| **2105** | **Нормативт зардал** | **68,996,780.73** | **315,819,788.86** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 56,136,470.73 | 288,210,273.83 |
| 210502 | Хоол, хүнс | 10,789,310.00 | 22,959,515.03 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,071,000.00 | 4,650,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **2,619,100.00** | **11,664,800.00** |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 00.00 | 997,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,619,100.00 | 10,667,800.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **1,211,700.00** | **1,118,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,211,700.00 | 1,118,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **16,695,699.00** | **7,125,200.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 12,827,334.00 | 4,000,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 648,000.00 | 1,820,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 80,000.00 | 65,400.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 80,000.00 | 44,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 44,000.00 | 55,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,450,655.00 | 00.00 |
| 210807 | Газрын төлбөр | 133,960.00 | 221,500.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 160,000.00 | 00.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 271,750.00 | 918,800.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **50,495,546.98** | **66,614,775.96** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,499,322.00 | 2,986,660.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 00.00 | 3,237,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 47,996,224.98 | 60,391,115.96 |
| **213** | **Урсгал шилжүүлэг** | **3,434,037.78** | **44,400,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 2,500,000.00 | 44,400,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 00.00 | 44,400,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,500,000.00 | 00.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 934,037.78 | 00.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 934,037.78 | 00.00 |
| **3** | **Үйл ажиллагааны ур дүн** | **58,079,670.64** | **434,109,961.00** |
| **145** | **Үйл ажиллагааны бус орлогын дүн** | 0.00 | 0.00 |
| **225** | **Үйл ажиллагааны бус зардлын дүн** | 400000.00 | 30,262,500.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 30,262,500.00 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 400,000.00 | 00.00 |
| **4** | **Үйл ажиллагааны бус үр дун** | **400,000.00** | **30,262,500.00** |
| **5** | **Нийт үр дун** | **57,679,670.64** | **403,847,461.00** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | 226,654,626.00 | 238,484,708.82 | -1,013,903.96 | 464,125,430.86 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **226,654,626.00** | **238,484,708.82** | **-1,013,903.96** | 464,125,430.86 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -7,959,062.58 | -7,959,062.58 |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **226,654,626.00** | **236,147,381.15** | **39,158,907.88** | 501,960,915.03 |
| D01 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **226,654,626.00** | **236,147,381.15** | **39,158,907.88** | 501,960,915.03 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 748,350.00 | 748,350.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **226,654,626.00** | **236,147,381.15** | **39,907,257.88** | 502,709,265.03 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -748,350.00 | 00.00 | -748,350.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 403,847,461.00 | 403,847,461.00 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **226,654,626.00** | **235,399,031.15** | **443,754,718.88** | 905,808,376.03 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн** | **674,351,540.00** | **991,539,785.00** |
| **11** | **Татварын орлого** | **00.00** | **00.00** |
| **12** | **Татварын бус орлого** | **166,330.00** | **00.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 166,330.00 | 00.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 166,330.00 | 00.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 166,330.00 | 00.00 |
| **13** | **Тусламж, санхүүжилтийн орлого** | **674,185,210.00** | **991,539,785.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 617,979,900.00 | 00.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 617,979,900.00 | 00.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 00.00 | 725,076,700.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 13,131,800.00 | 178,762,295.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 9,972,600.00 | 1,258,050.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 59,627,746.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 3,159,200.00 | 1,326,699.00 |
| 131107 | Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого | 00.00 | 116,549,800.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 00.00 | 72,219,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 00.00 | 72,219,900.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 43,073,510.00 | 15,480,890.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 43,073,510.00 | 15,480,890.00 |
| **2** | **Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн** | **650,879,540.00** | **867,683,506.83** |
| **21** | **Урсгал зардал** | **650,879,540.00** | **867,683,506.83** |
| **210** | **Бараа, ажил үйлчилгээний зардал** | **647,445,502.22** | **823,283,506.83** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 441,647,003.13 | 493,045,088.00 |
| 210101 | Үндсэн цалин | 273,859,703.13 | 309,621,359.00 |
| 210102 | Нэмэгдэл | 122,254,400.00 | 110,000,000.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 7,392,000.00 | 6,986,000.00 |
| 210104 | Урамшуулал | 38,140,900.00 | 50,802,729.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 00.00 | 15,635,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 55,283,072.59 | 64,447,828.83 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 38,052,555.96 | 45,060,888.83 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,307,655.63 | 4,922,368.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,445,983.00 | 3,937,973.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 861,269.00 | 979,875.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,615,609.00 | 9,546,724.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 49,166,900.00 | 68,219,900.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,730,809.00 | 5,122,150.00 |
| 210302 | Түлш, халаалт | 44,066,091.00 | 61,089,600.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 370,000.00 | 2,008,150.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 22,036,881.50 | 39,492,623.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 800,000.00 | 4,260,740.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,736,585.50 | 20,340,125.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 200,066.00 | 3,175,059.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 00.00 | 330,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,477,850.00 | 3,826,699.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,822,380.00 | 7,560,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 50,759,096.00 | 118,012,667.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 36,899,096.00 | 87,866,008.00 |
| 210502 | Хоол, хүнс | 9,860,000.00 | 25,146,659.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 4,000,000.00 | 5,000,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,130,000.00 | 16,700,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 00.00 | 7,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,130,000.00 | 9,700,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,211,700.00 | 1,118,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,211,700.00 | 1,118,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 17,710,849.00 | 7,857,400.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 12,827,334.00 | 4,000,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 648,000.00 | 1,820,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 80,000.00 | 65,400.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 80,000.00 | 44,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 44,000.00 | 55,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,450,655.00 | 00.00 |
| 210807 | Газрын төлбөр | 133,960.00 | 221,500.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 160,000.00 | 00.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1,286,900.00 | 1,651,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 5,500,000.00 | 14,390,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,500,000.00 | 11,153,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 00.00 | 3,237,000.00 |
| **213** | **Урсгал шилжүүлэг** | **3,434,037.78** | **44,400,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 2,500,000.00 | 44,400,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 00.00 | 44,400,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,500,000.00 | 00.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 934,037.78 | 00.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 934,037.78 | 00.00 |
| **3** | **Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | **23,472,000.00** | **123,856,278.17** |
| **5** | **Хөрөнгө оруулалтын мөнгөн зардлын дүн** | **23,472,000.00** | **123,391,400.00** |
| **22** | **Хөрөнгийн зардал** | **23,472,000.00** | **123,391,400.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 23,472,000.00 | 123,391,400.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 23,472,000.00 | 123,391,400.00 |
| **6** | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ** | **-23,472,000.00** | **-123,391,400.00** |
| **8** | **Нийт цэвэр мөнгөн гүйлгээ** | 00.00 | 464,878.17 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 464,878.17 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн** | **839,005,300.00** | **812,703,015.83** |
| **21** | **Урсгал зардал** | 839,005,300.00 | 812,703,015.83 |
| **210** | **Бараа, ажил үйлчилгээний зардал** | 839,005,300.00 | 812,703,015.83 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 463,162,900.00 | 453,171,786.00 |
| 210101 | Үндсэн цалин | 289,901,900.00 | 289,901,900.00 |
| 210102 | Нэмэгдэл | 110,000,000.00 | 110,000,000.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,986,000.00 | 6,986,000.00 |
| 210104 | Урамшуулал | 40,640,000.00 | 30,648,886.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 15,635,000.00 | 15,635,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 62,527,000.00 | 59,441,839.83 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 44,000,500.00 | 41,493,070.83 |

| | | | |
|---|---|---|---|
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,631,600.00 | 4,550,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,705,300.00 | 3,640,400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 926,300.00 | 910,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,263,300.00 | 8,847,969.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 68,219,900.00 | 68,219,900.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,010,300.00 | 5,122,150.00 |
| 210302 | Түлш, халаалт | 61,089,600.00 | 61,089,600.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,120,000.00 | 2,008,150.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 31,460,000.00 | 27,316,740.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 16,430,000.00 | 16,049,581.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,700,000.00 | 2,918,059.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 330,000.00 | 330,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,500,000.00 | 659,100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,500,000.00 | 6,360,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 57,204,600.00 | 54,069,550.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 42,209,000.00 | 39,073,950.00 |
| 210502 | Хоол, хүнс | 9,995,600.00 | 9,995,600.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 5,000,000.00 | 5,000,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 140,091,400.00 | 140,091,400.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 98,867,900.00 | 98,867,900.00 |
| 210602 | Тавилга | 24,523,500.00 | 24,523,500.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 7,000,000.00 | 7,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 9,700,000.00 | 9,700,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 258,000.00 | 194,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 258,000.00 | 194,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 7,081,500.00 | 6,627,800.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,000,000.00 | 4,000,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,100,000.00 | 1,100,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 65,400.00 | 65,400.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 44,500.00 | 44,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 55,000.00 | 55,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 221,500.00 | 221,500.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1,595,100.00 | 1,141,400.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 9000000.00 | 3570000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,000,000.00 | 3,570,000.00 |
| | **Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр** | **839,005,300.00** | **812,777,490.00** |
| **1310** | **Улсын төсвөөс санхүүжих** | 725,076,700.00 | 725,076,700.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 725,076,700.00 | 725,076,700.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 72,219,900.00 | 72,219,900.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 72,219,900.00 | 72,219,900.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 41,708,700.00 | 15,480,890.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 41,708,700.00 | 15,480,890.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | **74,474.17** |
| **62** | **Ажиллагсдын тоо** | 32 | 32 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 26 | 26 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 5 | 5 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн** | **178,371,891.00** |
| **21** | **Урсгал зардал** | **178,371,891.00** |
| **210** | **Бараа, ажил үйлчилгээний зардал** | **133,971,891.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **39,873,302.00** |
| 210101 | Үндсэн цалин | 19,719,459.00 |
| 210104 | Урамшуулал | 20,153,843.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **5,005,989.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 3,567,818.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 371,968.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 297,573.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 69,875.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 698,755.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **12,175,883.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 3,260,740.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,290,544.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 257,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,167,599.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,200,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **63,943,117.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 48,792,058.00 |
| 210502 | Хоол, хүнс | 15,151,059.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **924,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 924,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,229,600.00** |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 720,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 509,600.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **10,820,000.00** |

| | | |
|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,583,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,237,000.00 |
| **213** | **Урсгал шилжүүлэг** | **44,40,0000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 44,400,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 44,400,000.00 |
| **II** | **Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр** | **178,762,295.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **178,762,295.00** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 1,258,050.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 59,627,746.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,326,699.00 |
| 131106 | Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого | 116,549,800.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 390,404.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Бизкон Аудит ХХК-ийн  Хөвсгөл салбарын ахлах аудитор Л.Отгонбаяр, аудитор Ч.Мөнхбаяр нар гүйцэтгэж, хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Эрдэнэчимэг, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Бизкон Аудит ХХК-ийн Хөвсгөл салбарт  2022 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын Эрүүл мэндийн төв нь 2021 онд Иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг аюулгүй, чанартай жигд хүртээмжтэй хүргэх зорилтын хүрээнд:

- ✓ Урьдчилан сэргийлэх үзлэгийг 50 дээш хувьд хүргэх
- ✓ Эрүүл мэндийн боловсрол олгох
- ✓ Тоног төхөөрөмжөөр хангагдах
- ✓ Ээлтэй орчин бүрдүүлэх
- ✓ Эх хүүхдийн хяналтыг сайжруулах, эндэгдэлгүй ажиллах зорилготой Эрүүл мэндийн яамны салбар байгууллага бөгөөд 2021 оноос эхлэн аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллага болсон байна

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд: Засгийн Газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”-ыг хэрэгжүүлэх, “Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн хүснэгтийн Тэтгэврийн даатгал-Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "9.5" гэснийг "8.5" гэж, Тэтгэврийн даатгал-Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "9.5" гэснийг "8.5" гэж, Шимтгэлийн дүн-Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "12.7" гэснийг "11.7" гэж, Шимтгэлийн дүн-Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "12.5" гэснийг "11.5" гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн "12.5 хувиас" гэснийг "11.5 хувиас" гэж тус тус өөрчилсүгэй” гэж заасныг хэрэгжүүлж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд  өөрчлөлт хийсэн бөгөөд Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн  ангилал ашиглах заавар”-ыг шинэчлэн баталсныг мөрдөн ажиллаж  байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тус байгууллага нь 2020 онд улсын төсвийн байгууллага байсан бөгөөд 2021 оны санхүүгийн жилд орон нутгийн төсвийн байгууллага болсон байна. Орон нутгийн төсөвт байгууллага болсноор Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн А/375 дугаар захирамжаар баталсан НББББББ-ийг мөрдөн ажиллаж байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагад тайлант онд хөндлөнгийн хяналт шалгалт хийгдээгүй бөгөөд 2021 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийж, зөвлөмж хүргүүлсэн бөгөөд дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын Эрүүл мэндийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьаар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн болох 713.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 14.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 11.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тайлант онд 0.5 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна. Энэ нь ковид-19 цар тахалтай холбоотойгоор төрийн санд байршуулсан мөнгөн хөрөнгө байна.

Тайлант онд байгууллагаас авах авлага 52.8 сая төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд богино хугацаат өр төлбөр байхгүй байна.

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 67.9 сая байсан бөгөөд тайлант онд 234.4 сая төгрөг болж 166.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь аж ахуйн материал болон эм боох материалын үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 608.4 сая төгрөг байсан бөгөөд тайлант онд 618.1 сая төгрөг болж нэмэгдсэн нь тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр болон хандив тусламжаар тавилга, тоног төхөөрөмж бэлтгэн орлогод авсантай холбоотой байна. Үндсэн

хөрөнгө буурсан шалтгаан нь 24.4 сая төгрөгийн үлдэх өртөггүй ашиглах боломжгүй хөрөнгө акталсан, тайлант оны элэгдлийн зардлаас шалтгаалсан байна.

Тус байгууллагын санхүүгийн тайлангийн тодруулгад тайлант онд үүссэн авлага, үндсэн хөрөнгө, бараа материал болон мөнгөн хөрөнгө, төсвийн гүйцэтгэлийн талаарх бүхий л мэдээллийг бүрэн тусгасан байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн ИТХ-ын хуралдаанаар тус эрүүл мэндийн төвийн 2021 оны төсвийг баталсан байна. Эрүүл мэндийн төвийн төсвийг 2021 онд улсын төсвөөс 725.1 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас 41.7 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 72.2 сая төгрөгөөр нийт 839.0 сая төгрөгийн төсөв батлагдсан байна. Тайлант онд ажиллагсдын тоог 32-оор баталсан байна. Цагаан-Уул сумын Эрүүл мэндийн төв нь 2021 онд батлагдсан орон тоог хэтрүүлээгүй байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 839.0 сая төгрөгийн төсөв баталснаас 725.1 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, орон нутгийн төсвөөс 72.2 сая төгрөг, 41.7 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 725.1 сая төгрөгийн санхүүжилт, эрүүл мэндийн даатгалын сангаас 15.5 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 72.2 сая төгрөгийн нийт 812.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 812.7 сая төгрөгийг зарцуулж 74.4 сая төгрөгийг үлдэгдлээр тайлагнасан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламжаар 1.3 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 59.6 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1.3 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалаас 116.5 сая төгрөг нийт 178.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс 178. 4 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 0.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнажээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аудитаар онцлох асуудалтай зүйл байхгүй байна.

Бусад асуудлын тухайд: Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага:

- Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.
- Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

**3.8 Аудитын гол асуудал**

Засгийн Газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”-ыг хэрэгжүүлэх тогтоолд эрүүл мэндийн газар хамаарахгүй байна.

Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлангийн гол нөлөө бүхий асуудал нь: Ковид-1 цар тахалтай холбоотойгоор 1.5 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн нөөц үүсгэсэн байна. Мөн 0.5 сая төгрөгийн томилолтын зардал хэмнэсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 2.9 сая төгрөгийн нэмэлт орлогыг бүрдүүлж ажилласан байна.

**3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

**3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийг авч үзэхэд www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлбэл зохих 1,349.9 сая төгрөгийн /*давхардсан тоогоор*/ 173 мэдээллээс 1,349.9 сая төгрөгийн 170 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна. Хугацаа болоогүй 3 мэдээлэл байна.

**3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллагын худалдан авах ажиллагааны баримт материалыг хянаж үзэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй болно. Тайлант 298.8 сая төгрөгийн үнэ бүхий 40 удаагийн худалдан авах ажиллагаа зохион байгуулсан бөгөөд харьцуулалтын аргаар 13, шууд худалдан авах аргаар 27 арга хэмжээг зохион байгуулж ажилласан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчил, санал гомдол байхгүй байна.

**3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар ямар нэгэн зөвлөмж хүргүүлээгүй байна.

**3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар 43.2 сая төгрөгийн алдаа илэрснээс, 43.2 сая төгрөгийн алдааг залруулсан болно.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар 43.2 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн алдаа илэрснийг аудитын хугацаанд залруулсан болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын Эрүүл мэндийн төв | 1 | 43.2 | 1 | 43.2 | | | | | | |